

АРВАНХОЁРДУГААР ХАВСРАЛТ
“ДААТГАГЧААС ДААТГУУЛАГЧИД ТӨЛБӨРТЭЙГЭЭР МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ
БИЧИГ ӨГӨХ НӨХЦӨЛ, ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ХЭМЖЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгагчаас даатгуулагчид төлбөртэйгээр мэдээлэл, баримт бичиг өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээг тогтоохтой холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Даатгагчаас даатгуулагчид өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээ

2.1. Даатгагч даатгуулагчийн хүсэлтээр дараах мэдээллийг гаргаж өгнө:

2.1.1. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ;

2.1.2. Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгалын хэлбэрийн талаарх мэдээлэл;

2.1.3. Даатгалын компанийн бизнес төлөвлөгөө;

2.1.4. Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан Даатгалын компанид мөрдөгдөх “Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга” – ын дагуу гаргаж, аудитаар баталгаажуулсан жилийн санхүүгийн тайлан;

2.1.5. Жилийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн тайлан;

2.1.6. Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан Даатгалын компанид мөрдөгдөх “Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга” – ын дагуу гаргасан улирлын санхүүгийн тайлан;

2.1.7. Улирлын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн тайлан;

2.1.8. Давхар даатгалын төлөвлөгөө;

2.1.9. Аудит, бусад хяналтын байгууллагаас хийгдсэн тайлангууд;

2.1.10. Тухайн компанийн дотоодод мөрдөж буй эрх зүйн баримт, бичгүүд;

2.1.11. Даатгуулагчид өөрт нь холбоотой, үрэгдүүлж гээгдүүлсэн даатгалын гэрээ, гэрээний баталгааны хуулбарыг авах.

2.2. Даатгагч даатгуулагчид мэдээлэл өгөхдөө төлбөрийн хэмжээг дараах жишиг хэмжээг мөрдөнө:

2.2.1. Нэг нүүр баримт - 300 төгрөг;

2.2.2. Нэг нүүр тоон мэдээлэл - 500 төгрөг;

2.2.3. Жил, улирлын санхүүгийн тайлан - 1000 төгрөг;

2.2.4. Жил, улирлын төлбөрийн чадварын тайлан - 1200 төгрөг.

2.3. Даатгуулагч нь даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон даатгалын хэлбэрийн зөвшөөрлийн талаарх мэдээллийг даатгагчаас үнэ, төлбөргүй авах эрхтэй.

--ooOoo—